

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 06 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 оны 07 дугаар сарын 09

Улаанбаатар хот

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 05 дугаар сарын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын 40 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийт арга хэмжээний 70 хувь нь үр дүнтэй буюу 100, 22.5 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 90, 7.5 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 50-70 хувьтай тус тус үнэлэгдсэн байна. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай			Үр дүнгүй	Дундаж хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	
1	2	3	4	5	6	7	8
40	28	9	1	2	-	-	94.5

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 100, Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 95.7, “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 94, Бодлогын баримт бичигт

тусгагдсан зорилтын хүрээнд “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна” арга хэмжээнд тусгагдсан ажлууд 90 хувиар үнэлэгдсэн. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0-30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	1	-	1	-	-	-	90
2	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	4	3	-	-	-	95.7
3	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	30	22	5	1	2	-	94
4	Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ	2	2	-	-	-	-	100
Нийт		40	28	9	1	2	-	94.5

Зохион байгуулалтын нэгж тус бүрээр ангилан авч үзвэл (Хүснэгт 3):

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	30%	0%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Захиргаа, удирдлагын газар	17	13	3	-	1	-	-	95.3
2	Виз, зөвшөөрлийн газар	2	-	2	-	-	-	-	90
3	Иргэний харьяаллын газар	1	1	-	-	-	-	-	100
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	-	-	100
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	3	-	1	1	1	-	-	70
6	Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	3	3	-	-	-	-	-	100
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	3	2	1	-	-	-	-	96.7
8	Мэдээллийн технологийн хэлтэс	3	2	1	-	-	-	-	96.7
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	1	-	1	-	-	-	-	90
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	3	3	-	-	-	-	-	100
11	Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	-	100
Нийт		40	28	9	1	2	-	-	94.5

“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувьтай үнэлэгдсэн 9 арга хэмжээний биелэлт шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, “эрчимжүүлэх” шаардлагатай буюу 50-70 хувьтай үнэлэгдсэн 3 арга хэмжээний биелэлт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, тодорхой үр дүн гарсан хэдий ч хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа тул үнэлгээ буурч байгаа болно.

Эрчимжүүлэх шаардлагатай дараах арга хэмжээ байна. Үүнд:

Хүснэгт 4

Д/д	Арга хэмжээ	Зорилтот түвшин	Биелэлт
1	2	3	4
1 (16)	Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах	Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг зарлаж, зохион байгуулсан байна.	Хууль тогтоомжийн хүрээнд төрийн захиргааны албан тушаал, зарим төрийн үйлчилгээний албан тушаал төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжсэнтэй холбогдуулан мэдээллийн технологийн болон санхүүгийн чиг үүрэг хэрэгжүүлдэг 16 албан хаагчийг тусгай шалгалтад хамруулах захиалгыг салбар зөвлөлийн 06 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Мөн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр албан тушаалын ангилал, зэрэглэл ахисан, алслагдсан хилийн боомтод үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг орон нутаг дахь нэгжийн удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх, зарим газар, хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж байгаа тул шатлан дэвшүүлэх болзол, шаардлага хангасан төрийн жинхэнэ албан хаагчдыг тусгай шалгалтад хамруулах ажлын хүрээнд холбогдох журмын дагуу “төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд сэлгэн, шилжүүлэн ажиллуулах” зарыг 06 дугаар сарын 26-ны өдрөөс 5 хоног байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Төрийн албаны зөвлөлөөр албан тушаалын тодорхойлолт хянуулж, зөвшөөрөл авах ажлын явцтай холбоотойгоор удирдах, гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын хугацаа хойшлогдсон ба 07 дугаар сард багтаан зохион байгуулах юм.
2 (36)	Байгууллагын 2024 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах	Тендерийг худалдан авах ажиллагааны цахим системд нээлттэй зарлаж, шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан байна.	Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барилгын (Ховд, Жаргалант сум) ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг үнэлж, шалгарсан болон шалгараагүй аж ахуйн нэгж байгууллагад 06 дугаар сарын 27-ны өдөр мэдэгдэл хүргүүлэн гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангасан.
3 (38)	Байгууллагын эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд зохион байгуулах	Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн хагас жилийн тооллогыг нягтлан бодох бүртгэлийн хуулийн хугацаанд зохион байгуулж, үр дүнг удирдлагад илгэх хуудсаар тайлагнасан байна.	Байгууллагын даргын 06 дугаар сарын 21-ний өдрийн А/245 дугаар тушаалын дагуу хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 06 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна. Тооллогоор албан хаагчдын болон агуулахын бүртгэлтэй эд хөрөнгийг биет байдалтай тулган баталгаажуулж, үр дүнг удирдлагад илтгэх хуудсаар танилцуулах бэлтгэл ажлыг хангалаа.

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2024 оны 06 дугаар сард төлөвлөн гүйцэтгэсэн 40 арга хэмжээний хэрэгжилт 94.5 хувьтай үнэлэгдлээ. Цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50-70 хувьтай үнэлэгдсэн “Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах”, “Байгууллагын 2024 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах”, “Байгууллагын эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд зохион байгуулах” арга хэмжээг 7 дугаар сард хугацаанд нь зохион байгуулж, арга хэмжээ авах;

Зохион байгуулалтын нэгжүүд үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилтыг үр дүнд суурилсан, бодитой, биелэгдэхүйц, шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжихүйц (SMART) байхаар боловсруулах;

Төлөвлөгөөний “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” арга хэмжээ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаж, зорилтот түвшин нь “үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна” гэсэн тул засвар, хөгжүүлэлтийг тогтмол хийж, системийн үйл ажиллагааг сайжруулж, энэ ондоо багтаан жигдрүүлэх.

“Үр дүнтэй” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 28 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.